210201	Тэтгэврийн даатгал	3,618,481.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,100,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,520,044.00
210401	Бичиг хэрэг	1,149,100.00
210402	Тээвэр, шатахуун	7,121,450.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,623,494.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,626,000.00
2105	Нормативт зардал	105,320,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,320,500.00
210502	Хоол, хүнс	6,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	504,000.00
210702	Дотоод албан томилолт	504,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,902,527.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,902,527.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,195,684.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	109,190,215.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,005,469.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,534,949.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,817,846.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,817,846.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,717,103.45
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	261,455.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,455,648.45
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,059,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,059,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,059,700.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	344,656,275.45
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	344,656,275.45
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	86,556,894.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	68,134,782.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,852,099.45
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	171,112,500.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Манхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд авлага, шатахууны зарцуулалт, дотоод хяналт, зээлийн эргэн төлөлт, түүнчлэн аудитаар түүвэрт хамрагдсан ЗДТГ, ИТХ, Соёлын төвийн санхүүгийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчлүүдэд өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор У.Батчимэг 2022 оны 3 дугаар сарын 17-ноос 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Манхан сумын Засаг дарга 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 1/59 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Манхан сумын засаг дарга нь Хүний хөгжлийг эрхэмлэн дээдэлж, бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэн хөгжүүлж, төрийн бодлого шийдвэр, төсвийн бүрдүүлэлт, хуваарилалтыг оновчтой төлөвлөн, удирдлага арга зүйгээр хангаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, үйл ажиллагааныхаа чанар хүртээмжийг байнга сайжруулж, ёс зүйт, өндөр мэргэшсэн хүний нөөцөөр хангагдсан, төрийн үйлчилгээг иргэдийн хүсэл сонирхолд нийцүүлэн нээлттэй, ил тод, шуурхай, хүнд сурталгүй, чанартай хүргэх нутгийн захиргааны байгууллага болох зорилго тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулах
- Хүний хөгжил, нийгмийн харилцааны бодлого
- Эдийн засаг, хөдөө аж ахуйн бодлого
- Засаглалын бодлого
- Байгаль орчин, аялал жуулчлал
- Дэд бүтэц, газар зохион байгуулалт, төлөвлөлтийн бодлого

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Малын тоо толгойн албан татварын тухай хууль*
- *Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай*
- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Манхан сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2019-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2021 оны 03 дугаар сард дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Манхан сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 3,805.7 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 76.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 60.8 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Манхан сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 175.4 сая төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр өмчийн дансууд байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлан

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	105.10	182.70	-77.60	74%
Авлага	275.60	234.40	41.20	-15%
Бараа материал	291.10	345.50	-54.40	19%
	8,454.50	8,188.30	266.20	-3%

Үндсэн хөрөнгө				
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,126.3	8,950.9	175.40	-2%
Богоно хугацаат өр төлбөр	8.2	1.80	6.40	-78%
Цэвэр хөрөнгө, өмч	9,118.10	8,949.20	168.90	-2%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ	9,126.3	8,951.0	175.3	-2%
ӨМЧИЙН ДҮН				

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 105.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 182.7 сая төгрөг болж 77.6 сая төгрөгөөр буюу 74 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 77.6 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 275.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 234.4 сая төгрөг болж 41.2 сая төгрөг буюу 15 хувиар буурсан байна.

Хүснэгт 2: Авлагын үлдэгдэл

сая. төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.20	0.4	0.2
Төлбөртэй үйлчилгээний авлага		37.4	37.4
Байгууллагаас авах авлага	9.10	16.7	(2.4)
Хувь хүмүүсээс авах авлага	29.30	42.5	13.2
Зээлийн хүүгийн авлага	3.4	5.6	2.2
Тусгай зориулалтын сан			-
Дансны авлага /ОНӨААТҮГ/			-
Татвар, НДШ /ОНӨААТҮГ/			-
Татаас санхүүжилтийн авлага	10.6	2.8	(7.8)
Дүн	52.6	95.4	42.8
Урьдчилж гарсан зардал			-
Тусгай зориулалтын сан	223.0	129.0	(94.0)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа			-
Цалингийн урьдчилгаа			-
Томилолтын урьдчилгаа			-
Дүн	223.0	129.0	
АВЛАГЫН НИЙТ ДҮН	275.6	234.4	42.8

Эх сурвалж: Манхан сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд 234.4 сая төгрөгийн насжилт өндөртэй байгаа авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 275.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан. зээлийн хүүгийн 5.6 сая төгрөгийн авлага, зээлийн авлага 129.0 сая төгрөг, нийт 234.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 341.0 сая төгрөг болж 56.9 сая төгрөгөөр өссөн нь 56.9 сая төгрөгөөр эм боох материал, аж ахуйн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой нэмэгдсэн байна.Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 362.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 394.0 сая төгрөгөөр нийт 394.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 330.5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 11,074.2 сая төгрөг байсан бол оны эцэст 11,128.0 сая төгрөг болж 53.7 сая төгрөгөөр өссөн нь 12.6 сая төгрөгийн хөрөнгийг

худалдан авсан, 35.4 сая төгрөгөөр хандив, балансаас балансд шилжүүлэн авсан 55.9 сая төгрөг, үнэ төлбөргүй, бусад хөрөнгөтэй холбоотой 198.3 сая төгрөгөөр шилжүүлэн авсан холбоотой байна. Тайлант онд үндсэн хөрөнгө 12.6 сая төгрөгөөр төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн, 248.6 сая төгрөгөөр шилжүүлэн авсан, үнэ төлбөргүй хандиваар нэмэгдэж, акталсан, балансаас балансд шилжүүлсэн 248.6 сая төгрөгөөр хөрөнгө хасагдсан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 8.2 сая, эцсийн үлдэгдэл 1.8 сая төгрөг болж 6.4 сая төгрөгөөр буурсан байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 1.8 сая төгрөгийн өр байгаа нь дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой өглөгүүд байна. Үүнээс: Ажилчидтай холбоотой өглөг 0.1, байгууллагад өгөх өглөг 1.7, өглөгийн үлдэгдэл байна.

3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 7,678.3 сая төгрөг байсан оны эцэст 8,949.1 сая төгрөг тайлант онд 1,270.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 184.9 сая төгрөгийн алдагдалтай тайлагнахад 506.3 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон нь шол нөлөө үзүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,081.3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3,081.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Манхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 10 өдрийн 2/10 тоот тогтоолоор 3,081.3 сая төгрөгөөр баталж өмнөх оны болон тайлант оны давсан орлоготой холбоотойгоор 2021 онд 1 удаа тодотгол хийн 2021 оны 08 дугаар сарын 16-ны 3/04 тоот тогтоолоор нийт 3,161.1 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 3,161.1 сая төгрөгийн төсөв баталснаас 1,856.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 979.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 35.4 сая төгрөгийг ЭМДС-аас, 140.8 сая төгрөгийг ОНХС-аас 4.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 91.9 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас санхүүжүүлэн ажиллажээ.

Хүснэгт 3: Төлөвлөгөө, гүйцэтгэл

	сая. төгрөг	
	төлөвлөгөө	гүйцэтгэл
Улсын төсвөөс санхүүжих	1,927.2	1,856.8
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,927.2	1,856.8
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,120.4	1,120.1
Орон нутгийн төсвөөс	979.6	979.3
Орон нутгийн хөгжлийн сан	140.8	140.8
Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих	44.4	35.4
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	44.4	35.4
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	69.2	96.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	5.6	4.1
Туслах үйл ажиллагааны орлогоос	32.4	91.9
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	31.2	
ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	3,161.2	3,108.3

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,035.5 сая төгрөг буюу 96 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,200.1 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 363.6 бараа хангамж, бараа материалын зардал 59.2 томилолтын зардал 6.7, нормативт зардал 87.0 бараа үйлчилгээний бусад зардал 45.4, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 22.1 хөрөнгийн зардал 182.7, эргэж төлөгдөх зээл 0.03 сая төгрөгөөр тус тус зарцуулжээ.

Хүснэгт 4. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Орлогын ангилал	2021 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	112.7	181.6	(68.9)
Нийт орлого ба тусламжийн дүн	112.7	181.6	(68.9)
Татварын орлого	64.1	83.4	(1.6)
Орлогын албан татвар	-	-	-
Үйл ажиллагааны орлого	5.0	39.8	(34.8)
Шууд бус орлого	9.6	0.0	9.6
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	-	-
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт			-
Хөрөнгийн албан татвар	25.8	28.1	(2.3)
Бууны албан татвар	2.8	2.8	-
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	23.0	25.3	(2.3)
Хөрөнгө борлуулсаны албан татвар	-	-	-
Бусад татвар, төлбөр, хураамж	4.1	3.4	0.7
Улсын тэмдэгтийн хураамж	2.5	1.3	1.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	0.5	0.8	(0.3)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1.1	1.3	(0.2)
Газрын төлбөр	0.6	1.7	(1.1)
Газрын төлбөр	0.6	1.7	(1.1)
Байгалийн нөөц ашигласны төлбөр	19.0	10.4	8.6
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.4	0.7	(0.3)
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	17.1	8.5	8.6
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1.5	1.2	0.3
Татварын бус орлого	48.6	98.2	(49.6)
Нийтлэг татварын бус орлого	48.6	98.2	(49.6)
Торгуулийн орлого	48.6	98.2	(49.6)

Эх сурвалж: Манхан сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 181.6 сая төгрөг буюу 68.9 сая төгрөгөөр давуулжээ. Орлого давсан шалтгаан нь хөрөнгийн албан татварын орлого 0.5, үйл ажиллагааны орлого 34.8 Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 2.3 ,Хог хаягдлын үйлчилгээний хураамж 0,2 , Газрын төлбөр 1.1 ,Ус рашааны төлбөр 0.3 ,татварын бус орлого 49.6 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлж, улсын тэмдэгтийн хураамж 1.2, байгалийн нөөц ашигласны төлбөр 8.6, Ан амьтны нөөц ашигласны төлбөр 8.6, сая төгрөгөөр тасалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар ЗГНХ, ЗДН Хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 86.5, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 68.1, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 18.8, ЭМДС-аас Ковид-19 цар тахлын илүү цаг урамшуулал, эмийн зардалд 171.1 нийт 344.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 338.2 сая төгрөгийг Цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 39.9, НД-3.6, байр ашиглалтын зардалд 2.1, Хангамж бараа материалын зардалд 11.5, Норматив зардалд 105.3, томилолтын зардалд 0.5, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 1.9, Бараа үйлчилгээний бусад зардалд 111.2, бусад урсгал шилжүүлэгд 59,8 сая төгрөгийг тус тус зарцуулж орон нутгийн төсөвт 6.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Манхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангаас 2011-2020 онуудад олгосон 145 зээлдэгчийн 73.3 сая төгрөгийн зээл олгогдоноос 1 иргэн нас барсан, 113 зээлдэгч зээл бүрэн төлж дууссан, 22 иргэний 72.9 сая төгрөгийн зээл нь хэвийн төлөлттэй, 10 иргэний 61.9 сая төгрөгийн зээлийн авлага нь хугацаа хэтэрч байгаа нь сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.
2. “Эрчим Дөл” ХХК-тай 15 жилийн хугацаатай концессын гэрээ байгуулан сумын төсөвт байгууллагуудыг халаалт дулаанаар ханган ажиллаж тайлант онд өр төлбөр үүсээгүй тайлагнасан ч төсөвт байгууллагуудад батлагдсан төсвөөр гэрээ байгуулан зардлыг санхүүжүүлсэн байна.
3. Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, төсөвт төвлөрүүлээгүй **380.5** сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

3.8 Аудитын гол асуудал

Манхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд Эрүүл мэндийн төв Ковид-19 цар тахлын үйлчилгээ үзүүлсний төлбөрт ЭМДС-аас авах 38.3 сая төгрөг, тайлант онд 12 иргэнд малжуулах төслөөс 29.0 сая төгрөгийн зээл олгосонтой холбоотой авлага үүссэн асуудлууд нь нөлөө үзүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллүүдийг бүрэн оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3.5 сая төгрөгийн зөрчилд акт, 10.8 сая төгрөгт албан шаардлага, хариуцлага тооцох нэг албан шаардлага өгөгдсөн бөгөөд 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Ковид-19 цар тахал, малжуулах төсөлд хамрагдах иргэдийн сонгон шалгаруулалт ил тод нээлттэй эсэх, ОНХС-ийн тэжээлийн нөөцийн авлага барагдуулсан эсэх асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

3.13 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 5 тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Зөрчилгүй"-4 (сумын 12 жилийн сургууль, сумын хүүхдийн цэцэрлэг, ЭМТөв, Спорт цогцолбор) нийт 4 дүгнэлт гаргасан байна.

Манхан сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 35.0 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрч, 14.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага өгч, 20.7 сая төгрөгийн 5 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт -5 /сая.төг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
			Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1 Манхан сумын 12 жилийн сургууль	2	13.60								2	13.60
2 Манхан сумын хүүхдийн цэцэрлэг	1	6.20								1	6.20
3 Манхан ЭМТ	3	15.20					1	14.3		2	0.90
4 Спорт цогцолбор			-	-						-	-
Дүн	6.0	35.0	-	-	-	-	1.0	14.3		5.0	20.7

Эх сурвалж: Манхан сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.14 4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 218.4 сая төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс 60.0 сая төгрөгийн 2 алдааг залруулж, залруулагдаагүй зөрчилд 0.4 сая төгрөгийн 1 алдаа зөрчилд 1 төлбөрийн акт, 61.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 96.1 сая төгрөгийн 7 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. ОНХС-ийн тайланд авлага, тайлант үеийн үр дүн зөрүүтэй тайлагнасан 10.0 сая төгрөг,
2. Аймгийн ИТХ-ын 166 дугаар тогтоолоор 50.0 сая төгрөгийн өртөгтэй Дөргөн сумын ЗДТГ-ын FORLAND маркийн усны цистерн автомашиныг балансаас баланст шилжүүлснийг орлогод бүртгэв.

Шийдвэрлэсэн нь: 60.0 сая төгрөгийн 2 залруулга хийж сумын ТТЗ-ын тайланд залруулсан болно.

4.2 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Засаг даргын Тамгын газрын нярав М.Цолмонгийн хувийн дансаар нөөц хөрөнгөөс багш сурагчид, иргэдэд нэг удаагийн шагнал, урамшуулал олгохдоо хувь хүний орлогын албан татварын 10 хувийн суутгал ногдуулаагүй 0.2 сая төгрөг, соёлын төв хариуцсан нягтлан бодогч М.Бямбацэцэгт 1 хоног, төрийн сангийн мэргэжилтэн Б.Гантөмөрт 2 хоног нийт 0.1 сая төгрөгийн албан томилолт илүү олгосон, нийт 0.4 сая төгрөг олгосон зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" 20 зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах", гэсэн заалтуудыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3. Албан шаардлага

1. Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлээ хугацаандаа төлөөгүй насжин он дамжсан 10 иргэнтэй холбоотой 61.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн зөрчил илэрлээ. Энэ нь сум хөгжүүлэх сангаас олгох барьцаат зээлийн гэрээний 2.1.4-д "авсан зээл, түүний хүүгийн төлбөрийг энэхүү гэрээний хавсралтад заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд зээлдэгчийн харилцах данснаас үл маргах журмаар мөн зохих журмын дагуу зээлийг төлүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авна", 3.4-д "энэхүү гэрээтэй холбогдсон аливаа маргаан асуудлыг 2 тал хамтран оролцож шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэх боломжгүй бол асуудлыг Монгол улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4.4. Зөвлөмж

4.4.1 Төсвийн гүйцэтгэл, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Сумын төсөвт байгууллагын дүнгээр тогтмол зардлыг 365.9 сая төгрөгөөр төлөвлөж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан байна. Төрийн сангийн зарлагын хуулгаар 352.4 сая төгрөгийн зардал гаргаж 13.5 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардалд гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7-д "энэ хуулийн 22.2-т заасан төсвийн ангиллын төрөл бүрээр дэлгэрэнгүй ангилал тогтоох, түүнийг төсвийн төлөвлөлт, тайлагналт, гүйцэтгэлд ашиглах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно", 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг мөрдөн ажиллах заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн ангиллын дагуу төсөвт журмын дагуу зохицуулалт хийж зардлыг санхүүжүүлэн, Төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв илэрхийлж тайлагнах

4.4.2 Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт 2: Он дамжсан насжилт өндөртэй 5.1 сая төгрөгийн авлагыг тодорхой гарган эзэн холбогдогчдоор төлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллах. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", гэсэн заалттай нийцүүлж ажиллах.

Өгсөн зөвлөмж: Он дамжсан насжилт өндөртэй авлагыг эзэн холбогдогчдоор төлүүлэх.

4.4.3 Шатахууны зарцуулалт, дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт 3: Ажилтан албан хаагчдын хувийн унаанд шатахуун олгож албан хэрэгцээнд зарцуулсан, нийт 25.5 сая төгрөгийн жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв бодож баталгаажуулаагүй, шатахуун авч явсан ажлын тайлан, замын хуудас дутуу байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсыг сар бүр бүрэн бичүүлж, шатахууны тооцоог Зам, тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоолын холбогдох хавсралтын дагуу бодож хэвших.

4.4.4 ЗГ-ын 2021 оны 43-р тогтоолын зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт 4: ЗДТГ нь батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, хөрөнгө бэлтгэсэн, төсвийг үрэлгэн зарцуулсан зэрэг 41.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг баримталж ажиллах.

4.4.5 Түлээ, нүүрсний хөнгөлөлтийн талаар

Илрүүлэлт 5: Соёлын төв нь нийт ажилтан албан хаагчдад 2.3 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгожээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын дотоод журамд түлээ нүүрсний хөнгөлөлтийг хэдэн тонноор олгохыг нарийн тусган ажиллах.

4.4.6 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт 6: ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх өв соёлыг хамгаалах хөтөлбөр, бичлэгийн төлбөрийг санхүүжүүлэхээр хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулсан боловч тайлант тайлант хүлээж авах ажлын хэсэг томилогдоогүй, хөтөлбөрийн хүрэх үр дүнг бодитоор тооцоогүйгээр хөрөнгө шилжүүлсэн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" 20 дугаар зүйлийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн хөгжлийн сангийн журмыг мөрдөж, сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах талаар анхааран ажиллах,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 3-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хүснэгт – 6

/сая. төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗахирагч	1	13.5							1	13.5
2	Манхан ЗДТГ	5	122.2	1	50.0	1	0.4			3	71.8
3	Манхан ИТХ	-	-								
4	Манхан СХС	1	61.9					1	61.90		
	Манхан Соёлын төв	1	2.3							1	2.3
6	Манхан ОНХС	2	15.00	1	10.0					1	5.00
	Дүн	10	214.9	2.0	60.0	1.0	0.4	1.0	61.9	6.0	92.6


АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:



У.БАТЧИМЭГ